



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/366

Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Засаг даргын 2018 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/342 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх "Дундговь аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театр тоног төхөөрөмж"-ийг нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр "Монтех дистрибьюшн" ХХК-ийг сонгон 49,500,000 (дөчин есөн сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Техникийн тодорхойлолтын дагуу тоног төхөөрөмжийг, хүлээлгэж өгөхийг "Монтех дистрибьюшн" ХХК-ний захирал (Б.Ууганболд)-т үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Төв халхын дуулалт жүжгийн театрын дарга (Д.Доржсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

488010736